



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/59/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор                      Э.Сүнжидмаа Утас: 80048599      Цахим хаяг: <a href="mailto:Sunjidmaae@audit.gov.mn">Sunjidmaae@audit.gov.mn</a></p>
---	--

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа.....	16
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.010 № 153

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Монгол Элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тээвэр шатахууны анхан шатны бүрдэл хангалтгүй, төсвийн хэлбэлзэл зөрүүтэй, санхүүгийн тайланг татварын тодорхойлолт зөрүүтэй, төсвийн хэмнэлтийн гормыг зөрчсөн, үндсэн хөрөнгийн тооллогыг зөрүүтэй хийсэн, дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр хандив авсан, шаардахаар хуудасаар үндсэн хөрөнгө болон аж ахуйн материал зарлагдсан нийт 47.1 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020394

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,722,532.00</b>	<b>11,004,622.58</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>6,096,972.00</b>	<b>3,491,210.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,827,394.00	221,632.00
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	0.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>3,269,578.00</b>	<b>3,269,578.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	0.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,269,578.00	3,269,578.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,945,560.00</b>	<b>7,513,412.58</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>13,945,560.00</b>	<b>7,513,412.58</b>
35410	Бичиг хэргийн материал	0.00	130,000.00
35420	Аж ахуйн материал	13,054,800.00	5,430,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	818,400.00	1,946,366.02
35450	Барилгын засварын материал	0.00	0.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	72,360.00	6,946.56
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>680,000.00</b>	<b>0.00</b>
36600	Бусад нөөц	680,000.00	0.00
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>236,883,600.41</b>	<b>265,017,678.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>236,883,600.41</b>	<b>265,017,678.07</b>
39100	Газар	0.00	0.00
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>235,313,600.41</b>	<b>263,447,678.07</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,077,480.00	104,563,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,632,859.24	-5,756,046.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,646,073.78	106,286,073.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,513,993.05	-12,777,117.11
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,082,260.81	51,082,260.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,161,282.16	-39,356,468.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,134,518.43	10,528,318.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,543,598.20	-5,466,989.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,925,000.00	68,925,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,699,999.96	-14,580,833.28
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	0.00	0.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,570,000.00</b>	<b>1,570,000.00</b>
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,570,000.00	1,570,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>257,606,132.41</b>	<b>276,022,300.65</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,310,497.00</b>	<b>1,860,649.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,310,497.00</b>	<b>1,860,649.00</b>
<b>41100</b>	<b>Богино хугацаат үнэт цаас</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>3,310,497.00</b>	<b>1,860,649.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	1,211,006.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	0.00

<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>3,310,497.00</b>	<b>649,643.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	435,400.00	67,540.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,875,097.00	582,103.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>254,295,635.41</b>	<b>274,161,651.65</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>254,295,635.41</b>	<b>274,161,651.65</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	112,849,995.00	112,849,995.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>116,894,840.29</b>	<b>136,760,856.53</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	35,618,688.46	116,894,840.29
51220	Тайлант үеийн үр дүн	81,276,151.83	19,866,016.24
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,550,800.12	24,550,800.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>257,606,132.41</b>	<b>276,022,300.65</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>333,197,659.78</b>	<b>253,415,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>62,724,433.78</b>	<b>43,182,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>62,724,433.78</b>	<b>43,182,600.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>506,000.00</b>	<b>542,600.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	506,000.00	542,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	62,146,073.78	42,640,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	72,360.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>270,473,226.00</b>	<b>210,232,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>192,368,100.00</b>	<b>190,728,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	192,368,100.00	190,728,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>78,105,126.00</b>	<b>19,504,500.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	77,985,126.00	16,101,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,000.00	3,403,500.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>250,281,094.07</b>	<b>233,549,283.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>250,281,094.07</b>	<b>233,549,283.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>236,508,759.02</b>	<b>231,889,121.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>88,823,534.39</b>	<b>88,839,096.31</b>
210101	Үндсэн цалин	74,224,834.39	80,087,631.31
210102	Нэмэгдэл	11,168,400.00	6,615,945.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	2,135,520.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,060,125.79</b>	<b>15,768,323.38</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,520,884.74	11,229,272.06
210202	Тэтгэмжийн даатгал	884,810.73	1,134,762.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	707,847.40	907,809.25
210204	Ажилгүйдлийн даатгал	176,962.34	226,952.58
210205	Эрүүл мэндийн даатгал	1,769,620.58	2,269,526.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,459,000.00</b>	<b>4,162,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,285,600.00	3,423,500.00
210302	Түлш, халаалт	618,900.00	259,700.00
210303	Цэвэр, бохир ус	554,500.00	478,800.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,046,998.00</b>	<b>14,567,853.44</b>
210401	Бичиг хэрэг	707,200.00	453,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,531,298.00	12,750,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,480,600.00	1,207,540.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	327,900.00	156,313.44
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,732,645.60</b>	<b>237,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,732,645.60	237,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>413,500.00</b>	<b>129,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	133,100.00	129,400.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	280,400.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,788,000.00</b>	<b>1,904,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,788,000.00	1,904,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>79,236,710.77</b>	<b>77,812,325.92</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,515,010.77	77,135,925.92
210803	Даатгалын үйлчилгээ	267,300.00	267,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,400.00	123,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,948,244.47</b>	<b>28,468,322.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,008,994.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,200.00	82,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,866,050.47	28,385,722.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,772,335.05</b>	<b>1,660,162.37</b>

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,772,335.05	1,660,162.37
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,772,335.05	1,660,162.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	82,916,565.71	19,866,016.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,640,413.88	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,640,413.88	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	81,276,151.83	19,866,016.24
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	271,259,226.00	213,602,694.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	506,000.00	542,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	506,000.00	542,600.00
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	0.00	0.00
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	506,000.00	542,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	506,000.00	542,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	270,753,226.00	213,060,094.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	192,368,100.00	190,728,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	192,368,100.00	190,728,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,385,126.00	22,331,894.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	78,265,126.00	18,928,394.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,000.00	3,403,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	235,834,226.00	199,722,894.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	235,834,226.00	199,722,894.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,234,496.95	197,841,099.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	88,823,534.39	88,175,188.69
210101	Үндсэн цалин	74,224,834.39	68,532,554.69
210102	Нэмэгдэл	11,168,400.00	16,352,014.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	3,290,620.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,060,125.80	11,575,288.00

210201	Тэтгэврийн даатгал	7,520,884.75	8,005,191.36
210202	Тэтгэмжийн даатгал	884,810.73	892,524.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	707,847.40	714,019.30
210204	Ажилгүйдлийн даатгал	176,962.34	178,504.86
210205	Эрүүл мэндийн даатгал	1,769,620.58	1,785,048.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,459,000.00</b>	<b>4,162,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,285,600.00	3,423,500.00
210302	Түлш, халаалт	618,900.00	259,700.00
210303	Цэвэр, бохир ус	554,500.00	478,800.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,359,198.00</b>	<b>13,760,300.00</b>
210401	Бичиг хэрэг	345,400.00	479,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,442,298.00	11,932,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,480,600.00	1,257,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,900.00	90,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>237,600.00</b>	<b>237,600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	237,600.00	237,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>111,100.00</b>	<b>129,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	111,100.00	129,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,788,000.00</b>	<b>1,904,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,788,000.00	1,904,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>91,322,738.76</b>	<b>77,814,522.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,601,038.76	77,138,122.94
210803	Даатгалын үйлчилгээ	267,300.00	267,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,400.00	123,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,200.00</b>	<b>82,600.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,200.00	82,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,599,729.05</b>	<b>1,881,794.37</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>16,599,729.05</b>	<b>1,881,794.37</b>
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,772,335.05	1,660,154.31
213304	Хөрөнгийн	0.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,827,394.00	221,640.06
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>35,425,000.00</b>	<b>13,879,800.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>35,425,000.00</b>	<b>13,879,800.00</b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>35,425,000.00</b>	<b>13,879,800.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>35,425,000.00</b>	<b>13,879,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,425,000.00	13,879,800.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-35,425,000.00</b>	<b>-13,879,800.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,849,995.00	18,195,800.12	35,618,688.46	166,664,483.58
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,849,995.00	18,195,800.12	35,618,688.46	166,664,483.58
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	6,355,000.00	0.00	6,355,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	81,276,151.83	81,276,151.83
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	112,849,995.00	24,550,800.12	116,894,840.29	254,295,635.41
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	112,849,995.00	24,550,800.12	116,894,840.29	254,295,635.41
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	112,849,995.00	24,550,800.12	116,894,840.29	254,295,635.41
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,866,016.24	19,866,016.24
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	112,849,995.00	24,550,800.12	136,760,856.53	274,161,651.65

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>191,228,200.00</b>	<b>189,610,645.69</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>191,228,200.00</b>	<b>189,610,645.69</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>191,228,200.00</b>	<b>189,610,645.69</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>89,250,100.00</b>	<b>88,175,188.69</b>
210101	Үндсэн цалин	79,416,500.00	68,532,554.69
210102	Нэмэгдэл	6,403,300.00	16,352,014.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,430,300.00	3,290,620.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,048,800.00</b>	<b>11,575,288.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,478,800.00	8,005,191.36
210202	Тэтгэмжийн даатгал	892,500.00	892,524.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	714,000.00	714,019.30
210204	Ажилгүйдлийн даатгал	178,500.00	178,504.86
210205	Эрүүл мэндийн даатгал	1,785,000.00	1,785,048.32
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,163,800.00</b>	<b>4,162,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,293,400.00	3,423,500.00
210302	Түлш, халаалт	389,800.00	259,700.00
210303	Цэвэр, бохир ус	480,600.00	478,800.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,764,500.00</b>	<b>13,760,300.00</b>
210401	Бичиг хэрэг	482,800.00	479,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,932,300.00	11,932,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,258,500.00	1,257,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,900.00	90,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>237,600.00</b>	<b>237,600.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	237,600.00	237,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>129,400.00</b>	<b>129,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	129,400.00	129,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,918,000.00</b>	<b>1,904,200.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,918,000.00	1,904,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>69,633,400.00</b>	<b>69,584,069.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,911,700.00	68,907,669.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,300.00	267,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,400.00	123,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	231,000.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,600.00</b>	<b>82,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,600.00	82,600.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>191,228,200.00</b>	<b>189,610,645.69</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>190,728,200.00</b>	<b>189,068,045.69</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	190,728,200.00	189,068,045.69

35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	500,000.00	542,600.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	542,600.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>22,331,894.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	22,331,894.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	22,110,253.94
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	22,110,253.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		22,110,253.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	221,640.06
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	221,640.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		221,640.06
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>22,331,894.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	22,331,894.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	18,928,394.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	3,403,500.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 11 дугаартай албан бичгээр аудит хийлгэх хүсэлт ирүүлсэн боловч санхүүгийн тайланг 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдөр ирүүлж аудитыг 2022 оны 02 дугаар сарын 28-наас 2022 оны 03 дугаар сарын 1-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь: Байгаль орчны тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалах, хамгаалах, шинжлэн судлах чиг үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бусад бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Иймд дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг акрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 195.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 238.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Говь-Алтай аймгийн Монгол элсний улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.6 хувиар буюу 28.1 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Тус байгууллага нь 2020 онд санхүүгийн тайланд аудит хийлгээгүй тул эхний үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй байна.

Мөнгөн хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 6.0 сая төгрөг, 2.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 3.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь татаас санхүүжилтийн авлага 0.2 сая төгрөг, 3.3 сая төгрөг нь шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлага байна.

Өглөгийн эхний үлдэгдэл 3.3 сая төгрөг, үүнээс тайлант онд 1.5 сая төгрөгийг барагдуулж 1.8 сая төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна. Энэ нь хувь хүний орлогын албан татвар 1.2 сая төгрөг, хувь хүнд өгөх 0.6 сая төгрөг, байгууллагад 0.06 сая төгрөгийн өглөгтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.5 сая төгрөг болж 6.4 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 39.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 46.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 265.0 сая төгрөг болж өссөн байна. Тайлант онд 43.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч хандив тусламжаар 42.6 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 274.1 сая төгрөг болж 19.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 136.7 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 246.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 56.0 сая төгрөгөөр буурч, 190.7 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 2 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын болон орон төсвөөс санхүүжүүлэхээр 190.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын нутгийн төсвөөс 190.7 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 22.3 сая, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлого 0.5 сая төгрөг нийт 213.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 211.7 сая төгрөгийг зарцуулж 1.8 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 189.6 сая төгрөг буюу 99.0 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 22.3 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал зарцуулсан байна, 0.02 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй. Шийдвэргүй үлдэгдэлгүй болно.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

**Дараагийн жилийн аудитаар:**

1. Тээвэр шатахууны зардлын давтан үзэх
2. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал үзэх нь зүйтэй гэж үзлээ.
3. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 62.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.0 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 47.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 15.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

##### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

##### **4.3 Албан шаардлага**

Тээвэр шатахууны зарцуулалтыг тулган баталгаажуулахад анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй тооцоо бодох боломжгүй, нягтлан бодогчийн орлого нярвын тайлангаас 0.5 сая төгрөгөөр илүү, зарлага 0.7 сая төгрөгөөр дутуу үлдэгдэл 1.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 39 дүгээр тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлжээ.

Санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт 3.0 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/, 14.4.1-т /Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлаг", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлжээ

Хөрөнгийн тооллого 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"/, 12.2.1-т/жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлжээ

Дээд шатны төсөвт захирагчийн шийдвэргүйгээр 3.4 сая төгрөгийн хандив авч үйл ажиллагаандаа зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т "Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлжээ

Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 2 сарын 7-ны өдрийн 1.1-т/ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас, доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал

болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн горим зөрчиж 0.2 сая төгрөгийн зардлын санхүүжүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 1.4-т/энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны өр 0.6 сая төгрөгийг, авлага 3.3 сая төгрөгийг нийт 3.9 сая төгрөгийн өр авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ

Шаардахаар хуудсаар 15.2 сая төгрөгийн хөрөнгө зарлагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Монгол элсний УТХГНХЗ	9	62.3	1	15.0			8	47.6		
5	Дүн	9	62.3	1	15.0			8	47.6		